



ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 128

Чойбалсан

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 214 дүгээр захирамж, аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны А/21 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд судлан үзэж, 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд шуурхай шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Цэндарь -Хүний нөөцийн сургалт, мэргэжлийн зөвшөөрөл, шагнал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Б.Баяраа -Яаралтай, гамшгийн үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Б.Бибиш -Халдварт бус өвчний хавдрын сэргийлэлт эрт илрүүлэг, тандалт, бүртгэл хариуцсан мэргэжилтэн

2.Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тухай бүр шуурхай шийдвэрлэж байгаад хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэсэн талаарх мэдээллийг өдөр бүрийн 17 цагийн дотор аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ОЮУНАА

